



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
С.ЧИНЗОРИГ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс (978) 7011-0251,
И-мэйл comcor@iaac.mn, Вэб сайт http://iaac.mn

2023.11.27 № 02/19217

танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.2-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлж буй төлбөртэй тусламж, үйлчилгээтэй холбоотой дүрэм, журам, тарифыг судлан үзэж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Зөвлөмж хүргүүлж байна.

Зөвлөмжид дурдсан арга хэмжээг хэрэгжүүлж, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу биелэлт, үр дүнгийн талаар 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хариу ирүүлнэ үү.

Хавсралт ... хуудастай.

ДЭД ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Г. АЗЖАРГАЛ

142303019763

Авлигатай тэмцэх газрын
2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн
дугаар албан бичгийн хавсралт

02/19217

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЗӨВЛӨМЖ

УХАД-422 5120828

Авлигатай тэмцэх газраас төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлж буй төлбөртэй тусламж, үйлчилгээтэй холбоотой дүрэм, журам, тарифыг судлан үзэж, үүнтэй холбогдуулан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах ЗӨВЛӨМЖ-ийг хүргүүлж байна.

Зөвлөмж 1. Эрүүл мэндийн байгууллагын зарим захирал, эрхлэгч нараас хуулиар тусгайлан эрх олгоогүй байхад батлан мөрдүүлсэн дүрэм, журам, шийдвэрийг хүчингүй болгох, цаашид энэ төрлийн зөрчил давтан гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ авах.

Эрх зүйн зохицуулалт:

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төлбөрийн жишиг хэмжээг санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална." гэжээ.

Хүчингүй болгох шийдвэрийн жагсаалт:

Д/д	Байгууллагын нэр	Төлбөртэй тусламж, үйлчилгээний журам	Огноо, дугаар
1.	Амгалан амаржих газар	Төлбөрт үйлчилгээний төлбөрийг төвлөрүүлэх журам	2022.05.02-ны өдрийн А/21 тушаалын 2 дугаар хавсралт
2.	Гэмтэл, согор судлалын үндэсний төв	Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний журам	2022.11.29-ны өдрийн А/163 тушаалын 1 дүгээр хавсралт
3.	Геронтологийн үндэсний төв	Төлбөртэй үзүүлэх тусламж, үйлчилгээний журам	2022.06.02-ны өдрийн А/35 тушаалын 1 дүгээр хавсралт
4.	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам	2023.01.20-ны өдрийн А/14 тушаалын 2 дугаар хавсралт
5.	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Тусламж үйлчилгээний санхүүжилтийн журам	2022.05.27-ны өдрийн А/170 тушаалын 1 дүгээр хавсралт
6.	Улсын гуравдугаар төв эмнэлэг	Эмнэлгийн төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний журам	2022.05.18-ны өдрийн А/141 тушаалын 3 дугаар хавсралт
7.	Халдварт өвчин судлалын үндэсний төв	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн төлбөртэй тусламж, үйлчилгээний журам	2022.08.09-ны өдрийн А/184 тушаалын 1 дүгээр хавсралт
8.	Хүүхдийн төв сувилал	Хүүхдийн төв сувиллаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний журам	2022.09.02-ны өдрийн А/56 тушаалын 1 дүгээр хавсралт
9.	Эмгэг судлалын үндэсний төв	Эмгэг судлалын тусламж үйлчилгээг төлбөртэй үзүүлэх журам	2023.01.31-ний өдрийн А/12 тушаалын 2 дугаар хавсралт

Зөвлөмж 2. Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдаас баталсан төлбөрийн жишиг хэмжээг зөрчиж, төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийг тогтоосон шийдвэрийг дахин нягталж, хүчингүй болгох арга хэмжээ авах;

Дахин нягтлах, хүчингүй болгох шийдвэрийн жагсаалт:

Дд	Шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан	Шийдвэрийн огноо, дугаар	Үндэслэлгүйгээр тогтоосон төлбөр, хураамжийн агуулга
1.	Эмгэг судлалын үндэсний төвийн захирал	2023.01.31, А/112 (хавсралт 1)	Эмгэг судлалын лавлагаа лабораторид хийгдэх эсийн шинжилгээний төлбөрийг 50,000 төгрөгөөр тогтоосон.
<p>Тайлбар: Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 49,А/118 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ"-ний 782-792 дугаарт эмгэг судлалын шинжилгээний төлбөрийн жишигийг тогтоосон байх бөгөөд дээрх шийдвэрээр тогтоосон 50,000 төгрөгийн төлбөр нь ямар тусламж үйлчилгээний жагсаалтад хамаарах нь тодорхойгүй, мөн тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам"-ын 1.2-т заасан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгчид үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, жагсаалтыг энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан төлбөрийн жишиг хэмжээ, жагсаалтад заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй, код, ангиллыг өөрчлөхгүйгээр өөрийн байгууллагын үйлчилгээний хүрээнд тохируулан батална" гэсэнтэй нийцэхгүй байна.</p>			
2.	Эх хүүхдийн эрүүл мэндийн төвийн захирал	2022.04.04, А/46 (хавсралт 2)	- Жирэмсэн эмэгтэй болон 0-18 насны хүүхдээс бусад иргэн даатгуулагч Коронавируст халдварын U07 оношийн хөнгөн тохиолдлоор хэвтэн эмчлүүлсэн бол төлбөр төлнө. Оношийн хамааралтай бүлгийн заасан хэмжээгээр 100% төлнө.
<p>Тайлбар: - Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 08 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ"-ний 566-д U07 кодтой ОХБ(оношийн хамааралтай бүлэг)-т 3 сая төгрөгийн төлбөрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас төлж, иргэн төлбөр төлөхгүй байхаар зохицуулсныг зөрчсөн.</p>			
3.	Геронтологийн үндэсний төвийн ерөнхий захирал	2022.06.02, А/35 (хавсралт 3)	Зүрхний эхо – 40,000, Хэвлийн хөндийн хэт авиа оношилгоо - 25,000, Бамбай, үений хөндийн ЭХО - 25,000, Тархины судасны доплерографи - 40,000 төгрөгөөр тус тус тогтоосон.
<p>Тайлбар: Эрүүл мэндийн сайдын 2022 оны 49,А/118 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ"-ний 602-т Хэт авиа оношилгоо (зүрх, бамбай ... үе, тархины судасны доплер)-г 15,000 төгрөгөөр тогтоосныг зөрчиж, үндэслэлгүйгээр төлбөрийг 10,000-25,000 төгрөгөөр нэмэгдүүлсэн.</p>			
4.	Гэмтэл, согог, судлалын үндэсний төвийн ерөнхий захирал	2022.11.29, А/163 (хавсралт 3)	Гэмтэл, согог, судлалын үндэсний төвөөс иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ"-ний жагсаалтын: <ul style="list-style-type: none"> • 10-т Билирубин нийт - 8,000 төгрөг; • 11-т Билирубин шууд - 8,000 төгрөг; • 93-99-т өвчтөн тэзвэрлэхтэй холбоотойгоор тоноглогдсон автомашин хөдөө орон нутагт эмч, сувилагчгүй хүргэхэд цагт 10,000 төгрөг, нэмэлтээр шатахууны төлбөр 1 км 2,000 төгрөг, тоноглогдсон автомашин (эмч, сувилагчгүй) Улаанбаатар хотод 1 талдаа 50,000 төгрөг, эмч, сувилагчтай бол цагт 20,000 төгрөг, шатахууны төлбөрт 1 км нь 1,000 төгрөг, эмч 1 цаг нь 10,000 төгрөг, сувилагч 1 цаг нь 8,000 төгрөг, тэмцээн уралдаанд эмч, тоноглогдсон машинтай оролцоход 1 өдрийн 500,000 төгрөг, гадаад

			<p>оронд үйлчлүүлэгчийг тээвэрлэн хүргэх, авч ирэхэд 1 км-т (яаралтай болон түргэн тусламжаас бусад тохиолдолд) 2,000 төгрөг;</p> <ul style="list-style-type: none"> • 101-178-д ЭМД-д хамрагдаагүй иргэнд амбулаториор хийх 17 тусламж, үйлчилгээний төлбөрийг 5,000-100,000 төгрөг, сувилахуйн 5 тусламж, үйлчилгээг 1,000-2,000 төгрөг, үзлэг, оношилгоо шинжилгээг 57,000, үзлэгийг 15,000, сэргээн засах 34 эмчилгээ, үйлчилгээний төлбөрийг 2,500-15,000, уламжлалт 21 эмчилгээ, үйлчилгээний төлбөрийг 3,000-20,000 төгрөг; • 179-185-д ажлын бус цагаар үзүүлэх амбулаторийн 5 үзлэг, 2 өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ хийхдээ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан төлбөр дээр 15,000-150,000 төгрөгийг нэмж төлөхөөр тогтоосон зэрэг болно.
--	--	--	--

Тайлбар: Эрүүл мэндийн сайдын 2022 оны 49.А/118 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ"-ний жагсаалтын:

- 21-т Билирубин нийт - 3,000 гэж тогтоосныг зөрчиж, төлбөрийг 5,000 төгрөгөөр нэмэгдүүлсэн;
- 22-т Билирубин шууд - 3,000 гэж тогтоосныг зөрчиж, төлбөрийг 5,000 төгрөгөөр нэмэгдүүлсэн;
- 877-д Захиалгаар өвчтөн тээвэрлэх 1 км-т, яаралтай болон түргэн тусламжаас бусад тохиолдолд - 2,000 төгрөг /31406001 кодтой/-өөр тогтоосныг зөрчиж, үндэслэлгүй төлбөр хураамж тогтоосон;
- Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/216 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ын 1.4-т "Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орсон тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалгүй иргэнд үзүүлэх тохиолдолд эрүүл мэндийн даатгалд даатгуулахыг санал болгож, хэрэв татгалзсан тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу баталсан төлбөрийн хэмжээг баримтлан төлбөр авч тусламж, үйлчилгээг үзүүлнэ." гэж заасан байх ба Гэмтэл согог, судлалын үндэсний төвөөс тогтоосон дээрх төлбөр нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 08 дугаар тогтоолоор баталсан жагсаалтад нийцээгүй;
- Мөн ажлын бус цагаар үзүүлэх амбулаторийн 5 үзлэг, өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ хийхдээ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан төлбөр дээр 15,000-150,000 төгрөгийг нэмж төлөхөөр тогтоосон нь Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/216 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ын 2.9-т "Эрүүл мэндийн байгууллагууд энэхүү тушаалын хавсралтуудад заагдсан тусламж, үйлчилгээнээс бусад үйлчилгээнээс төлбөр авахыг хориглоно. Үүнд: ажлын бус цагаар үзүүлсэн тусламж, үйлчилгээ, шинжилгээний хариу өгөх, бие засах газар, нөмрөг, улавч, хувцас өлгөх, г.м нийтлэг үйлчилгээ хамварна...." гэж заасныг зөрчсөн.

5.	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын тушаал	2022.08.09, А/184 (хавсралт 2)	<p>1.Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, тарифын жагсаалтын:</p> <ul style="list-style-type: none"> • 2.1.11-т Ургацаг авах - 150,000 төгрөг; • 4.8-д Төлбөрийн баримт дахин хэвлүүлж, хуулбарлан авах - 2,500 төгрөг; • 2.1.4-2.1.13 буюу 10 тусламж үйлчилгээ(ажилбар)-ний төлбөрийг 30,000-45,000, 2.7.1-2.7.14 буюу чих хамар хоолойн 12 тусламж, үйлчилгээний төлбөрийг 5,000-150,000 төгрөг, 2.8.1-2.8.13 буюу физик эмчилгээний 13 тусламж, үйлчилгээний төлбөрийг 2,500-50,000 төгрөг, 4.12-т эмч дуудлагын хөлсийг 20,000 төгрөгөөр тус тус тогтоосон; <p>2.Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, тарифыг батлахдаа тусламж, үйлчилгээний нэр, төрлийн кодыг дурдаагүй.</p>
----	---	--------------------------------	---

Тайлбар.

- Эрүүл мэндийн сайдын 2022 оны 49,А/118 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ"-ний 728-д "Арьсны хоргүй хавдар, үү, ургацаг авах /байрлал хэмжээнээс хамаарч олон тооны жижиг хэмжээтэй бол/-д 80,000 төгрөгөөр тогтоосныг зөрчиж, 70,000 төгрөгөөр нэмэгдүүлэн тогтоосон;
- Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/216 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт"-д эмчийн үзлэг, лабораторийн дэмжлэгт тусламж, үйлчилгээ, физик эмчилгээ, чих, хамар, хоолойн зэрэг үйлчилгээг төлбөртэй авах талаар заагаагүй. Мөн Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/216 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ын 2.9-т "Эрүүл мэндийн байгууллагууд энэхүү тушаалын хавсралтуудад заагдсан тусламж, үйлчилгээнээс бусад үйлчилгээнээс төлбөр авахыг хориглоно. Үүнд: ажлын бус цагаар үзүүлсэн тусламж, үйлчилгээ, шинжилгээний харуу өгөх, бие засах газар, нөмрөг, улавч, хувцас өлгөх, г.м нийтлэг үйлчилгээ хамаарна..." гэж заасныг зөрчсөн;
- Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын тушаалаар "Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, тариф"-ыг батлахдаа тусламж, үйлчилгээний нэр, төрлийн кодыг дурдаагүй нь үйлчлүүлэгчийн зүгээс болон хяналт хэрэгжүүлэгч этгээдээс хяналт тавихад хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэсэн.

Зөвлөмж 3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй зарим байгууллагаас үзлэгийн төлбөрийг эмчийн, ахлах, тэргүүлэх болон клиникийн профессорын, зөвлөх эмчийн, гавьяат эмчийн, анагаах ухааны докторын үзлэг гэх мэтээр тогтоосон нь хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэхийг нягтлан дүгнэлт хийж, нэг мөр хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.

Нөхцөл байдал:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй зарим байгууллагаас эмчийн үзлэгийн төлбөрийг:

- Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн захирлын 2022 оны А/21 дүгээр тушаалаар гавьяат эмч, анагаах ухааны доктор, зөвлөх эмчийн үзлэгийг 35,000 төгрөг, тэргүүлэх зэрэгтэй клиникийн профессор эмчийн үзлэгийг 20,000-30,000 төгрөг;
- Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирлын 2022 оны А/30 дугаар тушаалаар эмчийн үзлэг(зэрэг цолгүй)-ийг 20,000 төгрөг, ахлах, тэргүүлэх, анагаах ухааны магистр болон клиникийн профессор эмчийн үзлэгийг 25,000 төгрөг, гавьяат эмч, анагаах ухааны доктор, зөвлөх эмчийн үзлэгийг 35,000 төгрөг;
- Геронтологийн үндэсний төвийн ерөнхий захирлын 2022 оны А/35 дугаар тушаалаар эмчийн үзлэг, зөвлөгөөг 15,000 төгрөг, зөвлөх зэргийн эмчийн үзлэгийг 25,000 төгрөг, гэрийн тусламж үйлчилгээний эмчийн үзлэг, зөвлөгөөг 25,000 төгрөг, зөвлөх зэргийн эмчийн үзлэгийг 30,000 төгрөг;
- Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2022 оны А/163 дугаар тушаалаар зөвлөх эмчийн үзлэг, оношилгоо шинжилгээний төлбөрийг 30,000 төгрөг, өвчний учир үзлэг, оношилгоо шинжилгээний төлбөрийг 57,000 төгрөг, өвчний учир үзлэгийн төлбөрийг 15,000 төгрөг;
- Халдварт өвчин, судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2022 оны А/184 дүгээр тушаалаар эмчийн үзлэгийг 20,000 төгрөг, ахлах, тэргүүлэх болон клиникийн профессор эмчийн үзлэгийг 25,000 төгрөг, гавьяат эмч, анагаах ухааны доктор, зөвлөх эмчийн үзлэгийг 35,000 төгрөгөөр тус тус тогтоожээ.

Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 264/А/293 тоот тушаалаар батлан мөрдөж байсан "Эмчийн үзлэгийн төлбөрийн жишиг хэмжээ" нь мөн сайд нарын 2022 оны 49,А/118 дугаар тушаалаар хүчингүй болсон байх ба үүнд ахлах,

тэргүүлэх, профессор, доктор, гавьяат эмчийн үзлэгийн төлбөрийг ялгавартай тогтоогоогүй.

Зөвлөмж 4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөртэй холбоотой асуудлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн агуулгад судалгаа, дүгнэлт хийж, зохих арга хэмжээг авах, шийдвэрлэлтийн талаар эрхлэх асуудлын хүрээний байгууллага, албан тушаалтанд үүрэг чиглэл өгч, биелэлтийг тооцох.

Нөхцөл байдал:

Нэг. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/216 дугаар тушаалаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ын 2.9-д "... Үйлчлүүлэгчийн автомашины зогсоол ашиглалтын төлбөрийг тухайн эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээ авсан тохиолдолд авахгүй." гэж заасан байх ба Эрүүл мэндийн яамны "Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө"-ний эхний хагас жилийн тайланд дурдсанаар тус яамны харьяа 19 байгууллага автомашины зогсоолтой бөгөөд 9 байгууллага нь төлбөргүй, 10 байгууллага нь төлбөртэй зогсоолын үйлчилгээ үзүүлдэг байна.

Эмнэлгийн гаднах зогсоолд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоолын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдээс төрийн байгууллагуудын уялдаа холбоогүйгээс үүдэн үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл, боломжгүй байгаа талаар, нөгөө талаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч буй иргэнээс төлбөр авч байна гэх гомдол, хүсэлт Авлигатай тэмцэх газарт удаа дараа ирсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Нийслэлийн Замын хөгжлийн газрын төлөөлөлтэй хамтарсан уулзалтыг¹ 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Уг уулзалтаар төрийн өмчит нэгдсэн, мэргэшлийн эмнэлгүүдийн гаднах авто зогсоолын төлбөртэй үйлчилгээ эрхлэхтэй холбоотой асуудал болон "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ын холбогдох зохицуулалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар харилцан санал солилцож, тодорхой шийдэлд хүрсэн. Энэ асуудлыг ойрын хугацаанд нэг мөр шийдвэрлэх шаардлагатай байна.

Хоёр. Авлигатай тэмцэх газарт хандаж нэр бүхий иргэнээс ирүүлсэн гомдолд Эрүүл мэндийн сайдын баталсан шийдвэрээр иргэн ажилд орох зорилгоор эрүүл мэндийн үзлэгт ороход 80,000 төгрөгийн төлбөр авч, ёс төдий үзлэг хийж, эрүүл мэндийн хуудас өгч байгаа нь сургуулиа төгсөөд ажилд орох гэж буй залуучуудад санхүүгийн дарамт болдог, ялангуяа хөдөө орон нутагт ажилд орох иргэдэд хүндрэлтэй байгаа нь Монгол Улсын Засгийн газрын баримталж буй иргэдийг хөдөө орон нутагт ажиллаж, амьдрахыг дэмжсэн бодлоготой нийцэхгүй байгаа талаар дурдсан байв. Уг асуудлыг судлан үзэхэд Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 49, А/118 дугаар тушаалаар баталсан төлбөрийн хэмжээ өмнө мөрдөж байсан буюу 2017 онд тогтоосон төлбөртэй харьцуулахад 20,000-60,000 төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгтээр харуулбал:

Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Шийдвэр, тогтоосон төлбөр		Зөрүү
	СС, ЭМС-ын 2017 оны 264/А/293	СС, ЭМС-ын 2022 оны 49/А/118	
Буу галт зэвсэг эзэмших сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлт гаргах	Тарифгүй	20,000	+20,000
Гадаад улсад явах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах	30,000	80,000	+50,000

¹ Уулзалтад Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын мэргэжилтэн Б.Батчимэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл, мэргэжилтэн Д.Батболд, Хууль зрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ө.Саранцэцэг, Нийслэлийн Замын хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн Ө.Төрбат, мэргэжилтэн О.Ганчимэг, М.Тогтохсүрэн нар оролцов.

Гэр бүл болох, ажил сургуульд орох зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах	20,000	80,000	+60,000
Жолооны үнэмлэх авах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах	20,000	50,000	+30,000

Авлигатай тэмцэх газраас Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд иргэдээс гаргасан энэ талаарх гомдол, мэдээллийг тодорхой цаг хугацаа (4 сарын хугацааны мэдээлэл)-г хамааруулан түүвэрлэн судлахад гэр бүл болохтой холбоотой 2, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дэвтэр авахтай холбоотой 8, ажилд орохтой холбоотой 3, жолооны үнэмлэх авахтай холбоотой 5 гомдол байв. Гомдлын шийдвэрлэлтийн тэмдэглэлээс үзэхэд үзлэг оношилгоог сайжруулах, зарим нарийн мэргэжлийн шинжилгээний үнэ нэмэгдсэн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ шинэчлэн баталсан гэсэн агуулгаар шийдвэрлэсэн байна.

Нийслэлийн 9 дүүргийн Эрүүл мэндийн төвөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, зөвлөгөө өгөхтэй холбоотой жишиг тарифын талаар судалгаа авч, дүн шинжилгээ хийхэд үзлэгийн төлбөр шинэчлэн батлахаас өмнө болон хойш харилцан адилгүй хэмжээтэй байсан байна. Тухайлбал, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 264/А/293 дугаар тушаалаар "гэр бүл болох ажил, сургуульд ороход эрүүл мэндийн дүгнэлт гаргах төлбөрийн жишиг хэмжээ"-г 20,000 төгрөгөөр тогтоосон байх үед буюу 2021 онд Багануур дүүрэг 15,000, Багахангай дүүрэг үнэ төлбөргүй, Баянзүрх дүүрэг 30,000, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүд 10,000, Сүхбаатар, Налайх дүүрэг 20,000 төгрөгийн төлбөр авч, үйлчилгээ үзүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, зарим дүүргийн Эрүүл мэндийн төв жишиг төлбөрөөс өндрөөр, зарим Эрүүл мэндийн төвүүд доогуур, зарим нь жишиг төлбөрийн дагуу авч байсан байна. Харин Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49,А/118 дугаар тушаалаар "гэр бүл болох ажил, сургуульд ороход эрүүл мэндийн дүгнэлт гаргах төлбөрийн жишиг хэмжээ"-г 80,000 төгрөгөөр шинэчлэн баталсны дараа буюу 2022 оны 04 дүгээр сараас 08 дугаар сарын байдлаар Багануур, Налайх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүд уг үйлчилгээг 80,000, Хан-Уул дүүрэг 45,000, Сүхбаатар дүүрэг 40,000, Баянзүрх дүүрэг 30,000, Багахангай дүүрэг үнэ төлбөргүй үзүүлсэн байв. Дээрх байдлаас дүгнэлт хийхэд уг үйлчилгээний төлбөрийн хэмжээг орон нутгийн нөхцөл байдал, амьжиргааны түвшин зэргээс шалтгаалан уян хатан төлбөрийн зохицуулалттай байх боломжтой байна.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР